

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ БОЛОВ.

Монголбанкны Хяналтын зөвлөлийн хурал 2011 оны 5 дугаар сарын 6-ны өдөр хуралдаж төлөвлөгөөнд тусгагдсан ажил болох 2010 оны Монголбанкны захиргаа, аж ахуйн төсөв, зардлын болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлийг шалгасан Хяналтын зөвлөлийн гишүүн Д.Моломжамц, Монголбанкны Зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилт, үр дүнгийн байдалтай танилцаж шалгасан Хяналтын зөвлөлийн гишүүн Ч.Энхбаатар, Монголбанкаас Арилжааны банкуудад тавих хяналтыг сайжруулах талаар хийсэн ажилтай танилцаж шалгасан Хяналтын зөвлөлийн гишүүн Я.Эрхэмбаяр нарын мэдээллийг тус тус хэлэлцээд Монголбанкны удирдлагад дараах зөвлөмжийг хүргүүлэхээр тогтсон байна. Үүнд:

- Арилжааны банкууд үйл ажиллагаандаа Банкны тухай Монгол Улсын хууль, эрх зүйн зарим актыг бүрэн хэрэгжүүлэхгүй байгаад судалгаа хийж, шалтгааныг тогтоож, дүгнэлт гаргаж ажиллах;

- Арилжааны банкуудын үйл ажиллагаанд Хяналт шалгалтын газраас хийсэн шалгалтын дүнг цаг хугацаанд нь хэлэлцэж, зохих шийдвэр гаргаж ажиллах;

- Хяналт шалгалтын газрын хянан шалгагчийг ажилд авах, бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

- Монголбанкны Зөвлөлийн шийдвэрийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулж, биелэлтийг дүгнэх шат дараалсан хариуцлагын тогтолцоог бий болгож ажиллах;

- Зөвлөлийн хурлын баримт бичиг, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг электронжуулж цаг хугацаа, зардал хэмнэх, хурлын тэмдэглэлийн менежментийг боловсронгуй болгох;

- Банкны тухай хууль, эрх зүйн бусад актад тусгагдсан болон тухайн газар, хэлтэс, албадын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх журам зааврыг тухай бүр шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах, түүнийг ажлын хэрэгцээнд зориулан эмхэтгэл байдлаар гаргах;

- Монголбанкны төсөвт тодотгол хийх шаардлага гарсан үед орлого, зарлагыг өөрчлөхөд хүргэж байгаа хүчин зүйлүүдийг нэг бүрчлэн тооцож болзошгүй зардлын санг бий болгох үндсэн дээр төсвийн тодотгол хийхээс аль болох зайлсхийх;

- Монголбанкны Хяналтын зөвлөлийн тогтоолоор өгсөн зөвлөмж бүрийг анхааралдаа авч түүнийг хэрэгжүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулах.

2010 онд Монголбанкны системийн хэмжээгээр аж ахуйн үйл ажиллагаанаас 642.2 сая төгрөгийн орлого оруулж, 8,439.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 502.5 сая төгрөгийн орлого оруулж орлогын төлөвлөгөө 21.8 хувиар тасарсан нь зарим орлогыг үндэслэл муутай төлөвлөснөөс шалтгаалсан, Монголбанкны төсөвт 2010 оны сүүлчийн өдөр тодотгол хийсэн нь тодотголын агуулга, мөн чанар, ач холбогдлыг бууруулж байгааг, Хяналтын зөвлөлөөс төсөв, хөрөнгө оруулалтын чиглэлээр 2009, 2010 онд 2 тогтоолоор Монголбанкны

Ерөнхийлөгчид давхардсан тоогоор 9 заалт бүхий зөвлөмж өгсний хэрэгжилт сайнгүй байгааг Хяналтын зөвлөлийн хурлаас тэмдэглэсэн байна.

Өнгөрсөн онуудтай харьцуулахад төсвийн гүйцэтгэлийг тооцоо, судалгаа сайтай, зардлын өөрчлөлтийг нөлөөлсөн хүчин зүйлээр гаргаж ирүүлснийг сайшаан тэмдэглэж, тус банкны жилийн төсөв, зардал, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийн асуудлыг Хяналтын зөвлөл анхааралдаа авах нь зүйтэй гэж үзэв.

Монголбанкны Захирлуудын Зөвлөл 2010 онд 45 удаагийн хурлаар 222 асуудал хэлэлцэж, холбогдох газар, хэлтэс, албанд бодлогын болон үйл ажиллагааны чиглэлээр 205 үүрэг даалгавар өгсөн байна. Үүрэг даалгаврын 187 буюу 91.2 хувь нь биелсэн, хугацаа хоцорч биелсэн 3, хойшлогдсон 3, хугацаа хараахан болоогүй 4 үүрэг даалгавар байгаа нь өмнөх онуудтай харьцуулбал өгсөн үүрэг даалгаврын тоо, биелэлтийн хувь аль аль нь өсч Монголбанкны үйл ажиллагаанд газар, хэлтэс албад жигд оролцож буйг харуулж байна. Монголбанкны Зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврын бүртгэл сайжирч, хэрэгжилтэд тавих хяналт тогтмолжсон байна гэж үзэв.

Монголбанкны Зөвлөлийн 2010 оны шийдвэрийн хэрэгжилт хэвийн байгаа ч зарим шийдвэрийн биелэлтийг баримт, нотолгоо муутай гаргасан, бүрэн биелсэн гэх үүрэг даалгаврын дотор эргэлзмээр зүйл байгааг Хяналтын зөвлөлөөс тэмдэглэв.

Мөн Хяналтын зөвлөлөөс Монголбанкны ажлын чанар, нэр хүнд нь Хяналт шалгалтын газрын ажлын үр дүн, идэвх санаачлагаас хамаарч буйг харгалзан тус газрын үйл ажиллагааг шинэчлэх, үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, хяналт шалгалтын ажлын технологийг шинэчлэх талаар анхаарч бүтцийн өөрчлөлт хийж 2010 онд Зайнаас хяналт тавих хэлтсийг шинээр байгуулж ажилласан нь Монголбанкаас Арилжааны банкуудад тавих хяналтыг тогтмолжуулах, банкны тухай хууль, эрх зүйн актыг хэрэгжүүлэх, хоёр талын хамтын ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн байна гэж үзэв.

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ